



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ ДОКТОР А.ГАЛТБАЯР
ТАНАА

**МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 7,
Утас: 32-71-99, Факс: (976-11) 32-43-31,
<http://www.ulaanbaatar.mn>

2014. 06. 09 № 22/1508
танай _____ -ны № _____ -т

**"Улаанбаатар Марафон" Олон улсын
гүйлт зохион байгуулах тухай**

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот маань өдрөөс өдөрт өргөжин тэлж, цэцэглэн хөгжиж байгаагийн дээр хүн амын суурьшил төвлөрөл ихтэй дэлхийн томоохон хотын түвшинд хүрээд байна.

Бид улс орноо хөгжүүлэх, нийслэл хотоо өнгө үзэмжтэй байлгах, нийслэлчүүдээ эрүүл аюулгүй орчинд амьдруулж, сэтгэл хангалуун байлгахын тулд бодлогын олон чухал арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Энэхүү ажлын хүрээнд Монгол улсын нийслэл Улаанбаатар хотоо олон улсад сурталчилсан, дэлхийд нэртэй холын зайн гүйгчид болон нийслэлийн иргэд маань хүсэн хүлээж байж оролцдог "Улаанбаатар Марафон" Олон улсын гүйлтийн тэмцээнийг энэ оноос эхлэн уламжлал болгон зохион байгуулахаар бэлтгэл ажилдаа ороод байна.

"Улаанбаатар Марафон" Олон улсын гүйлт нь Монгол улсын Засгийн газрын 2013 оны 325 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 14-ний едрийн А/161 дүгээр захирамжаар 2014 оны 06 дугаар сарын 07-ны билэгт сайн өдөр болох бөгөөд анх удаа 30 мянгаас дээш гүйгчдийг оролцуулан зохион байгуулагдах гэж байна.

Гүйлтийн үйл ажиллагаанд танай сургууль хамт олон ажилтан, албан хаагчид, оюутан залуучуудаа уриалан өргөнөөр оролцуулж хамтран ажиллана гэдэгт найдаж байна.

Танай байгууллага, хамт олон гүйлтэнд оролцохдоо өөрсдийн хүмүүнлэгийн ажлын чиглэл, зорилгоо тодорхойлон хуримтлал үүсгэж тодорхой үйл ажиллагааг санхүүжүүлж, ажиллахыг уриалж байна. Гүйлтэнд оролцсон, хүмүүнлэгийн чиглэлээр хийсэн ажлынхаа мэдээллийг хавсралтын дагуу бидэнд ирүүлж хамтран ажиллана уу.

"Улаанбаатар Марафон" Олон улсын гүйлт нь эрүүл мэндийнхээ төлөө сайн дурын, хүмүүнлэгийн үйл ажиллагаа болж байгаагаараа онцлог тул танай байгууллагаас энэхүү үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг НЗДТГ-ын "ulaanbaatar.mn" сайт болон хэвлэл мэдээллээр олон нийтэд байнга сурталчлах болно.

Хавсралт *1* хуудастай.

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН
ОРЛОГЧ



Ц.ЭНХЦЭНГЭЛ

111020001466

УРИАЛГА

2014 оны 05 дугаар
сарын 05-ны өдөр

Улаанбаатар
хот

Эрхэм хүндэт Та бүхнийг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод анх удаа 30 гаруй мянган хүнийг хамруулан зохион байгуулагдах гэж буй “Улаанбаатар-Марафон” Олон улсын гүйлтэд байгууллага, хамт олон, гэр бүлээрээ нэгдэн идэвхтэй оролцохыг уриалж байна.


“Улаанбаатар-Марафон” гүйлтэд та бүхэн нэгдсэнээр өөрийн биеэр эрүүл мэнддээ хөрөнгө оруулалт хийж, сонирхсон зайндаа гүйж, өөрийгөө сорихын зэрэгцээ нийгэмд тустай хүмүүнлэгийн ажлыг санаачлан, зохион байгуулах боломжийг олгож байна.

Энэхүү ажлын хүрээнд хандив тусламж хуримтлуулан өөрийн байгууллагын гүйгчдийн энгэрийн дугаар, дурсгалын зүйлсийг авч өгөх, хөгжлийн бэрхшээлтэй, эмзэг бүлгийн болон амьдралын гачигдалтай хүмүүст туслах, ногоон байгууламж, эко байгаль орчноо хамгаалах зэрэгт чиглэгдсэн үйл ажиллагааг явуулж болно.

“Улаанбаатар-Марафон” гүйлтэд оролцсон хүмүүсийн нэрс, тоо, хүмүүнлэгийн үйл ажиллагааныхаа чиглэл, хуримтлуулсан мөнгөний хэмжээ болон зарцуулалтын талаарх мэдээллээ [/ub_nbtsq@yahoo.com/](mailto:ub_nbtsq@yahoo.com) бидэнд ирүүлвэл та бүхний идэвх оролцоо сайн үйлсийн талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах болно.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

**“УЛААНБААТАР-МАРАФОН” ОЛОН УЛСЫН
ГҮЙЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО**



**"УЛААНБААТАР МАРАФОН" ОЛОН УЛСЫН
ГҮЙЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР**

Нэг. Зорилго:

1. Эх орондоо гүйлтийн спортыг хөгжүүлэх, нийслэл хотоо дэлхийн улс орнуудад сурталчилах, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх, өсвөр залуу үеийнхэнд өөрийн дотоод нөөц боломжийг нээж зорилгосоо хүрэх тэсвэр хатуужилтай болгон бие бялдрын болон оюун санааны өв тэгш хүмүүжил төлөвшүүлэхэд "Улаанбаатар Марафон" олон улсын гүйлтийг зохион байгуулахын зорилго оршино.
- 1.2 Хамрах хүрээ: "Улаанбаатар Марафон" олон улсын гүйлтэд гүйлтээр хичээллэдэг гадаад, дотоодын иргэд гүйгчид, их дээд сургуулийн оюутнууд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, нийслэлийн иргэд 25-30 мянган хүнийг хамруулна.

Хоёр. "Улаанбаатар Марафон"-ы зохион байгуулагч, хамтрагч, ивээн тэтгэгчид

Ерөнхий зохион байгуулагчид Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар

Хамтран зохион байгуулагчид Боловсрол, шинжлэх ухааны яам, Нийслэлийн Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харъяа газрууд Монголын Үндэсний Олимпын хороо, Монголын Хөнгөн атлетикийн холбоо, Монголын хэт холын марафон гүйлтийн холбоо, "Ар Монгол" триатл групп, Монголын залуучуудын холбоо, Монголын оюутны холбоо

Гурав. Зохион байгуулах журам, хугацаа:

3.1 "Улаанбаатар - Марафон" олон улсын гүйлтийн нээлтийн ажиллагаа 2014 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 09.00 цагт Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд болно.

Гүйлт Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайгаас гараанаас гаргаж, тус бүрийн маршрутаар гүйж Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд барианд барина

Тэмцээн - 1. Марафон

18-аас дээш настай марафон гүйлтээр тогтмол хичээллэгчдийн дунд хагас марафон /21095 м/ бүтэн марафон /42190м/ гүйлтийн тэмцээнийг зохион байгуулна.

Гүйгчдээс бүртгэлийн хураамж авна. Хураамжаа төлсөн гүйгчдийн бүртгэлийг баталгаажуулж энгэрийн дугаар, футболк алчуур, танилцуулга, гүйлтийн маршрут зэргийг олгоно. Хураамж төлөөгүй гүйгчдэд энгэрийн дугаар олгохгүй бөгөөд дугаар аваагүй гүйгчдийг барианд Зарихгүй ба амжилтыг тооцохгүй. Мөн эрүүл мэндийн үйлчилгээ тусламжийг авах боломжгүй болно.

Тэмцээн- 2. Сонирхогчдын гүйлт:

Сонирхогчдын гүйлтийг 4 насны ангиллаар 4 зайд зохион байгуулна.

- 17 нас хүртэл 4000 м /эр, эм, зөвхөн сонирхогчдын дунд/
- 18-35 нас 8000 м, /эр, эм, зөвхөн сонирхогчдын дунд/
- 36- 49 нас 5000 м /эр, эм, зөвхөн сонирхогчдын дунд/
- 50-иас дээш нас 4000 м /эр, эм, зөвхөн сонирхогчдын дунд/

Гүйлтэнд оролцогчдод энгэрийн дугаар олгоно. Гүйлтэнд оролцогчдыг бүртгэх ажлыг 2014 оны 04 дүгээр сарын 20-ноос эхлэн 06 дугаар сарын 06-ны өдрийг дуустал зохион байгуулна.

Бүртгэлд хувь хүн, гэр бүл, албан байгууллагаараа хамрагдаж болно.

Дөрөө. Шагнал урамшуулал

"Улаанбаатар - Марафон" гүйлтийн хагас буюу бүтэн марафоны 21095м, 42190м зайд гүйж эхний 1-6 дугаар байрт шалгарсан эрэгтэй, эмэгтэй тамирчдад алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагнал, өргөмжлөлөөр шагнана. Барианд орсон бүх тамирчдыг дурсгалын медаль, өргөмжлөлөөр шагнана.

Хагас марафон /21095 м/ гүйлтийн шагнал	I байр	2500\$
	II байр	2200\$
	III байр	1800\$
	IV байр	200\$
	V байр	180\$
	VI байр	160\$
Бүтэн марафон /42190 м/ гүйлтийн шагнал	I байр	5000\$
	II байр	4000\$
	III байр	3000\$
	IV байр	300\$
	V байр	250\$
	VI байр	200\$

4000 м, 5000 м, 8000 м зайд гүйж эхний 1-3 дугаар байрт шалгарсан эрэгтэй, эмэгтэй тамирчдад алт, мөнгө, хүрэл медаль, мөнгөн шагнал, өргөмжлөлөөр шагнана.

4000 м гүйлтийн шагнал	I байр	100\$
	II байр	80\$
	III байр	60\$
5000 м гүйлтийн шагнал	I байр	120\$
	II байр	100\$
	III байр	80\$
8000 м гүйлтийн шагнал	I байр	200\$
	II байр	160\$
	III байр	120\$

Тав. Бүртгэлийн ажиллагаа

5.1. Бүртгэлийг 2014 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрийн 17:00 цаг хүртэл Нийслэлийн Биеийн тамир, спортын газар /Соёлын төв өргөөний 1 дүгээр давхарын 13 тоот/-ын өрөөнд хийнэ. Бүртгэлд биээр ирж болон онлайнаар хамрагдаж болно.

Гүйлтэнд оролцох хүсэлтэй гадаад, дотоодын иргэд бүртгэлийн маягтыг үнэн зөв бөглөж зургаа нааж ирүүлнэ.

- 5.2. Бүртгэлд хамрагдах гүйгчид иргэний үнэмлэх болон өөрийнхөө төрсөн он, сар, өдрийг баталгаажуулах бичиг баримт, тухайн тамирчны оролцох зайд гүйж болохыг зөвшөөрсөн эмчийн бичиг, гадаадын тамирчид эрүүл мэндийн даатгал зэргийг авч ирнэ.
- 5.3. Сонирхогчдын гүйлтэд оролцогчдод, энгэрийн дугаар олгоно. Энгэрийн дугаар аваагүй гүйгчдийг барианд барихгүй бөгөөд үзүүлсэн амжилт хугацааг тооцохгүй.
- 5.4. Хагас, бүтэн марафон гүйлтэнд оролцогчид гараанд гарахаас өмнө эмчийн хяналтад хамрагдан даралтаа хэмжсэн байна.
- 5.5. Бусад зайд гүйгчид гүйлт болохоос 3 хоногийн дотор эмчийн үзлэгт хамрагдан зүрхний цохилт, даралтаа хэмжүүлсэн байна.
- 5.6. Хөдөө, орон нутгаас оролцож байгаа тамирчдын байр, хоол, ирэх буцах унааны зардлыг тэмцээнд оролцуулж байгаа тухайн байгууллага буюу тухайн тамирчин өөрөө хариуцна.
- 5.7. Чингисийн талбай руу срох, гарах хөдөлгөөнийг 8:30 минутад хязгаарлан хаах тул гүйлтэнд оролцогчид Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай, гарааны шугамын ард 8:30 минутаас өмнө ирж байрлалаа эзэлсэн байна. Гүйгчдийн бүртгэлд хамрагдсан дарааллыг харгалзан гарааны шугамны ард байрлуулна.
- 5.8. Тэмцээний өдөр бүртгэл хийхгүй. "Улаанбаатар – Марафон" олон улсын гүйлтэнд оролцсоор гадаад орноос буюу өөр аймаг, хотоос ирж байгаа урьдчилан бүртгүүлсэн тамирчдад 2014 оны 06 дугаар сарын 07-ны өдөр 07:00 – 08:00 цагт энгэрийн дугаарыг нь олгоно.
- 5.9. Бүртгэлийн хуудас, гүйлтийн хураамжийг төлөх дансны дугаарыг www.sport.ub.gov.mn сайтад байршуулсан байна.
- 5.10. Гүйлтийн 42190 м, 21095 м, 8000 м-ийн зайд уралдах гүйгчид 15000 /арван таван мянга/, 4000 м, 5000 м-ийн зайд уралдах монголын гүйгчид 2000 /хоёр мянга/ төгрөгийн хураамж төлнө.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Соёлын төв өргөө, Монголын Театрын музейн, 3-н давхарт

Шуудангийн хаяг

Төв шуудан -13/236

Утас: 312786, 328977, 99178373

Факс: 976-11-328977

E-mail: it@sport.ub.gov.mn

Нийслэлийн Биеийн тамир,
спортын газар

"Улаанбаатар Марафон" Олон улсын гүйлт, хүмүүнлэгийн
ажлын тухай мэдээлэл

Байгууллагын нэр

2014 оны ... дугаар сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

№	Байгууллагын нэр	Албан хаагчдын тоо	Гүйлтэнд оролцох хүний тоо	Зохион байгуулсан хүмүүнлэгийн ажлын зорилго, чиглэл	Санхүүжилтын хэмжээ	Үр дүн
1.						
2.	с					

МЭДЭЭ ГАРГАСАН
АЛБАН ТУШААЛ

ГАРЫН ҮСЭГ

ГАРЫН ҮСГИЙН ТАЙЛАЛ